

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ч.БҮЖИНЛХАМЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин/ биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ХАНГУУЛАХ							
1.1 Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл, хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилго, чиг үүргийн хүрээнд:							
1	Арга хэмжээ №1.1.1 Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 14 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх (Өмнөговь аймгийн уул уурхайн нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд)	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; эрсдэлийн ангилал буурсан объектын хувь;	-	100%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Зам тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 13-07/05 дугаартай удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан хад суурьшлын бүсэд нүүрс ачиж, буулгах талбайн үйл ажиллагаа явуулж буй 14 аж ахуйн нэгж, байгууллага төлөвлөгдөн зарлагдсанаас 6 аж ахуйн нэгж, байгууллага буюу 42.9 хувь нь хамрагдсан. Хяналт шалгалтаар 8 аж ахуйн нэгж буюу 57 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй зогссон тул хяналт шалгалтад хамрагдаагүй байна. Хяналт шалгалтаар нийт 223 зөрчил илрүүлэн илрүүлсэн зөрчлийг арилгуулахаарулсын ахлах байцаагчийн заалттай 6 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтийг тооцон ажилласан. Илэрсэн зөрчлийн дагуу холбогдох	2023.05.07 2023.05.28	100%

					хууль тогтоомжоор зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулан 4 аж ахуйн нэгж байгууллагад 12,000.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж бүрэн барагдуулсан. Хяналт шалгалтад хамрагдсан 7 аж ахуйн нэгж, байгууллагын талбайн зохицуулагч, дугуйт ачигчийн оператори, гар буулгагч 21 ажилтны өртөж буй цулцанд нэвтэрдэг тоосны 21 сорьц авсан ба 5 буюу 23.8 хувь нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.2-10.1 дахин их, кварц цахиурын тоосны 7 сорьцын 4 буюу 57.1 хувь нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.4 - 4.4 дахин их, талбайн нийт тоосны 7 сорьцын 6 буюу 85.7 хувь нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 8.62 - 669.63 мг/м³-ээр их буюу 1.86 - 67.9 дахин их, нүүрс ачиж буулгах талбайн орчны PM₁₀, PM_{2.5} тоосны 14 сорьц цуглуулснаас PM_{2.5} тоосны агууламж эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 6.75 – 18.85 мг/м³-ээр их буюу 39.4 – 378 дахин их, PM₁₀ тоосны агууламж эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.4 – 24.2 мг/м³-ээр их буюу 15-243 дахин их, 7 аж ахуйн нэгжийн нүүрс ачиж буулгах талбайн 21 ажилтны хөдөлмөрийн нөхцөлд хийсэн бичил цаг уур, шуугиан, доргионы хэмжилтээр агаарын хэм 22 ажлын байранд буюу 73.3 хувьд нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.9-3.6 хэмээр их, агаарын харьцангуй чийглэг нийт ажлын байранд 7.7 - 28.3 хувиар бага, дугуйт ачигчийн операторийн өртөж буй доргионы түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.61-23.209 м/с²-аар их буюу 1.7-27.9 дахин их доргионы нөлөөлөлд өртөж байгаа нь эрүүл ахуй, стандартын шаардлага хангахгүй байна.		
2.	Арга хэмжээ №1.1.2 Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр,	Хяналт шалгалт хийсэн объектын тоо; эрсдэлийн	Хяналт шалгалтад 418 аж ахуйн нэгж, байгууллага буюу	100%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 13-07/04 дугаартай	2024.04.01 2024.10.30	100%

	хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр хийсэн хяналт шалгалтад дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудад уламжлах	ангилал буурсан объектын хувь; -100%	хамрагдаж, 4101 зөрчил илрүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 314 аж ахуйн нэгжид улсын /ахлах/ байцаагчийн 3173 заалттай хамтарсан албан шаардлага хүргүүлсэн. 31 аж ахуйн нэгж, байгууллагад 47250.0 мян.төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.		удирдамжийн дагуу 377 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийхээс 286 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан. Шалгалтаар нийт 2305 зөрчил илрүүлснээс 1046 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 114 байгууллагад 1307 заалттай албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 10 аж ахуйн нэгж, байгууллагад 28,500.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулан бүрэн барагдуулсан. Шөнийн цагийн нэмэгдэл, хөдөлмөрийн чадвар түр алдалт өвчлөл, ээжлийн амралт, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгоогүй зэрэг 41 аж ахуйн нэгж байгууллагад улсын ахлах байцаагчийн актаар 72.842.220 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, барагдуулж ажилласан. Хяналт шалгалтын дүнд дүн шинжилгээ хийж байна.		
3.	Арга хэмжээ №1.1.3 Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	-	Гүйцэтгэл 100 %	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан 13-07/11 тоот удирдамжийн хүрээнд 17 Аймаг, Нийслэл, Дүүргийн нутаг дэвсгэрт эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 99 аж ахуйн нэгж, байгууллага, 6 иргэн хамрагдаж, нийт 208 зөрчил илэрснээс 80 буюу 38 хувийг газар дээр нь арилгуулж, 16 аж ахуйн нэгж байгууллагад 128 заалт бүхий, бүхий улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлагыг тус тус хүргүүлэн, биелэлт 87 хувьтай байна. Шалгалтаар 1 аж ахуйн нэгжийн 1 ажилтны ээлжийн амралтын хоногийн зөрүү болох 373656 (гурван зуун далан гурав зургаан зуун тавин зургаан) төгрөгийг нөхөж олгох тухай улсын ахлах байцаагчийн акт тогтоож хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	2024.03.04 2024.10.01	100%

					Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 1 дэх заалтад заасны дагуу 1 аж ахуйн нэгжид хялбаршуулсан журмаар 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгөөр торгуулийн арга хэмжээг авч ажилласан байна. Хяналт шалгалтын дүнд дүн шинжилгээ хийж байна.		
4	Арга хэмжээ №1.1.4 Уул уурхай, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудад уламжлах	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	60 аж ахуйн нэгж байгууллага хяналт шалгалтад хийж, 1107 зөрчил илрүүлэн, 415 заалт бүхий 54 албан шаардлагыг хүргүүлж, 15 аж ахуйн нэгж, байгууллагад 38,500.0 мян.төгрөгийн шийтгэл ногдуулж, барагдуулсан.	100%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/07 дугаартай “Уул уурхай, нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу хяналт шалгалтад 186 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж, нийт 2920 зөрчил илэрснээс 218 буюу 7.4 хувийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 1793 заалттай 161 албан шаардлага хүргүүлж, 47 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хялбаршуулсан журмаар 76,250.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, 100% барагдуулсан. Нийт 44 аж ахуйн нэгж байгууллагад 370 хүний илүү цаг, ээлжийн амралт, шөнийн цагийн нэмэгдэл хөлс, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зэрэг 573,435,800 /таван зуундалан гурван сая дөрвөн зуун гучин таван мянга найман зуу/ төгрөгийн улсын ахлах байцаагчийн актыг тогтоосон байна. Хяналт шалгалтын дүнд дүн шинжилгээ хийгдэж байна.	2024.03.01 2023.10.30	100%
5.	Арга хэмжээ №1.1.5 Соёл, урлагийн байгууллагуудад хөдөлмөрийн харилцаа, аюулгүй байдал, нийгмийн хамгааллын асуудлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 3 байгууллагад	Хяналт шалгалт хийсэн объектын тоо 3; эрсдэлийн ангилал буурсан объектын	-	100%	ХНХ-ын Салбарын улсын ерөнхий байцаагч болон Соёлын салбарын улсын ерөнхий байцаагч нарын хамтран баталсан “Хяналт шалгалт хийх тухай” 13-07/13 дугаартай удирдамжийн дагуу Чингис хаан Үндэсний музей, Улсын Филармони, Улсын Хүүхэлдэйн театрт холбогдох улсын байцаагч нартай хамтран хяналт шалгалтыг 07.2.1 кодтой	2024.04.01 2024.10.25	100%

	хийх	хувь;			"Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах хяналтын хуудас"-аар хийж, нийт 15 зөрчил илрүүлсэн. Илэрсэн зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.		
6.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ Зөрчил арилгалт /хувь/	100%	100%	Тайлангийн хугацаанд нийт 14 албан бичиг, 3 өргөдөл хүсэлт хүлээн авч, 21 албан бичиг төлөвлөн хүргүүлсэн байна.	2024.01.02 2024.12.30	100%
7.	Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын актыг хянан баталгаажуулах	Хянан баталгаажуулсан актын тоо	100%	100%	Хянан баталгаажуулах хурц хордлогын акт ирээгүй.	2024.01.02 2024.12.30	100%
2. ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ							
2.1 ЭРСДЭЛД СУУРИЛСАН САЛБАРЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЭН МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ИРГЭДИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГУУЛАХ, ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД ХӨДӨЛМӨРЛӨХ ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ БҮХИЙ ҮР ДҮНТЭЙ ЦОГЦ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
2.1.3	Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 2024 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт-1	100%	100%	Салбарын хяналтын газрын 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан хөнгөн, хүнс, хөдөө аж ахуй болон эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдламж боловсруулан агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлсэн. Хяналт шалгалтын танилцуулгыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж байна.	2024.01.02 2024.12.30	100%
2.1.4	Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, батлуулах <i>/Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9.2.1, 5.19/</i>	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлийн хяналтын хуудасны тоо-1	100%	100%	Хөдөлмөрийн эрүүл ахуйг шалгах 07.2.1 кодтой хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/42 тушаалаар батлуулан, яамны сайтад байршуулсан.	2024.01.02 2024.03.01	100%

3. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
3.1	Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулахад санал өгөх	Журам-2		100%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын зохицуулах журмын төсөлд саналд өгсөн.	2024.01.02 2024.12.30	100%
3.2	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, хуулийн этгээдүүдийг хууль зүйн мэдээллээр хангасан байна.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг гүйцэтгэсэн байна.	100%	100%	Зам, тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, зөрчилтэй байсан 4 аж ахуйн нэгж байгууллагад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулан, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 12000.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, бүрэн барагдуулсан.	2024.04.01 2024.09.30	
4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
4.1 Хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй, хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилтын хүрээнд:							
4.1.1	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор улсын байцаагчдыг чадавхижуулах сургалтыг танхимаар зохион байгуулах,	Салбарын хяналтын чиглэлээр баримталж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулах, шинээр батлагдсан хөдөлмөрийн эрүүл ахуйн стандартуудыг танилцуулах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах, мэргэшил арга зүйгээр хангах,	-	100%	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газар хамтран Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдыг чадавхижуулах 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад ГБХНХЯ-ны Салбарын хяналтын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын /ахлах/ 17 байцаагч хамрагдсан. Сургалтад “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын бодлого, үйл ажиллагаа” “ДЭМБ-аас эрүүл ахуйн хяналтын чиглэлээр баримталж буй чиглэл, стратеги”, “Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал”, “Төрийн албаны шинэтгэл-төрийн албан хаагчийн ёс зүй”, “ОУХБ-ын 81,	2024.04.01 2024.10.01	100%

		хяналт шалгалтын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх			129 дүгээр конвенцод Монгол Улс нэгдэн орохын ач холбогдол", "Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал", "Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага-SOFT SKILL", "Зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа, шинээр гарсан эрхзүйн зохицуулалт" сэдвүүдээр тухайн салбарын мэргэжилтэн, доктор, профессор, прокурор нар тус тус хичээл орсон.		
4.1.5	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн явц, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100%	100%	Засгийн газрын 420 дугаар тогтоолоор батлагдсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, Хяналт үнэлгээний үндэсний хороонд хүргүүлсэн. 2024 оны хяналт шалгалтын тоон тайланг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийсэн. 2025 онд хийгдэх хяналт шалгалтын объектыг батлуулах сайдын тушаалын төсөл гарган, хянуулж байна. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ажилласан.	2024.01.02 2024.12.30	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилтэд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон орон нутгийн салбар нэгжүүдтэй хамтран үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулах	Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилт хангалтгүй	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөж буй стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж,	Яамны харьяа асрамж, халамж, сэргээн засах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын мөрдөж буй стандартын хэрэгжилтэд үзлэг шалгалт хийх Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/133 дугаар тушаалын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээх засах төвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт	2024.11.06 2024.12.20	

			байна гэх мэдээлэл ирдэг	холбогдох саналыг бодлогын газар хүргүүлэх	хийж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын өгсөн үүрэг даалгаварын дагуу Дашваанжил ХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	0	0	Хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах	ХНХЯ-ны салбарын хяналтын газрын дарга, УУХҮЯ-ны Салбарын хяналтын газрын дарга, ЗТХЯ-ны Салбарын хяналтын газрын дарга нарын баталсан удирдамжийн дагуу Дашваанжил ХХК-д холбогдох улсын байцаагч нартай хамтран төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчдын 26 заалт бүхий хамтарсан албан шаардлага хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан. Шалгалтын дүнг Шадар сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	2024.02.01 2024.03.15	100%
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор холбогдох байгууллагуудад албан даалгавар хүргүүлэх	Албан даалгавар-1	2023 онд Улсын ерөнхий байцаагчийн 07/00-00/001 албан даалгаварыг хүргүүлсэн байна.		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангаж, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Салбарын улсын ерөнхий байцаагчийн 07/00- 00/001-04, 05 дугаартай албан даалгаврыг БХЯ, ЗХЖШ, ОБЕГ, ХААХҮЯ, ЭХЯ-ны хөдөлмөрийн аюулгүй байдал,	2024.03.15	100%

					эрүүл ахуйн салбар хороонд, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд, МҮЭХ, МАОЭНХ, МҮХАҮТ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зэрэг байгууллагад тус тус хүргүүлсэн.		
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Гандантэгчилэн хийдийн лам хүүхдүүдийн дотуур байранд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/01 дүгээр “Албан даалгавар”-ын хэрэгжилтийг шалгах ажлын хэсэгт ажиллах	0	0	0	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/01 “Албан даалгавар”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Төв-Гандантэгчэнлин хийдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын үеэр Гандантэгчлэн хийдийн холбогдох албан тушаалтнуудад илэрсэн зөрчил дутагдлыг хэрхэн арилгах, дацангуудын гал тогоонд ажиллагсадын хөдөлмөрийн эрүүл ахуй, тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа, стандарт шаардлагыг хангаж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтын танилцуулгыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн.	2024.01.25	100%
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, түүний харьяа дүүргийн Хөдөлмөр,	0	0	0	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/31 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын /ахлах/ байцаагчдын 2024 оны эхний 8 дугаар сарын байдлаарх хяналт	2024.09	100%

	халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ажиллаж буй хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын (ахлах) байцаагчдын үндсэн чиг үүргийн хэрэгжилт, түүний үр дагаварт үнэлгээ хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлт боловсруулах зорилгоор хяналт үнэлгээг зохион байгуулах				шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хэрэгжилт хангагдаагүй, үр дүн тодорхойгүй, хүрч чадаагүй зорилт арга хэмжээний шалтгаан, нөхцлийг тодорхойлох, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах, улсын байцаагчдын үйл ажиллагаа нь чиг үүрэг хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгаа эсэх болон түүний үр дагаварт үнэлгээ хийсэн. Үнэлгээний хүрээнд СУЕБ-ийн 2024 оны 07/00-00/001-09 дугаартай Сахилга хариуцлага, бүтээмжийг дээшлүүлэх тухай албан даалгаврыг хүргүүлсэн.		
6.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Олон улсын хүүдийн Найрамдал цогцолборт гарсан хоолны хордлогод газар дээр нь ажиллах	-	-	-	Газрын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Олон Улсын Найрамдал цогцолборт гарсан хоолны хордлогын нөхцөл байдалд 2024 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 3-ны өдрүүдэд Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын Тамгын газрын дарга Ш.Чинбат болон мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан НЭМГ-ын Сонгинохайрхан дүүрэг хариуцсан эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар хордлогын голомтонд ажиллаж, цайны газрын 08 дугаар 28-наас 30-ны өдрийн хоолны цэсэнд орсон 58	2024.08.30 2024.10.01	100%

					төрлийн хоолноос шинжилгээнд дээж авсан. Мөн 11 хүнсний бүтээгдэхүүн, эрүүл зүйн шинжилгээнд тогооч нарын гар, угаасан аяга таваг, сав суулганаас 30 арчдас, өвлийн байрны цайны газар, гадна талбайн шүүлтүүрийн уснаас 2 дээж авч, НЭМГ-ын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн саналаар прокурорын тогтоолоор зуны болон өвлийн цайны газрын үйл ажиллагааг зогсоож, зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж байна. Хяналт шалгалтаар уны байрны цайны газрын аяга таваг угаалгын хэсгийн усны крант ажилладаггүй, халуун тогоонд ус халааж, аяга таваг угаах тосгуурт хувингаар зөөж хийн аяга тавгаа угаадаг, аяга таваг хатаах зориулалтын камергүй, угаасан аяга тавгийг зориулалтын бус дугуйтай төмөр сагсанд хураасан, цайны газрын хоол үйлдвэрлэлийн хэсэг, аяга угаалгын хэсгийн бохир ус зайлуулах трапууд хаалт хамгаалалтгүй учир хүн хальтирч унах эрсдэл үүссэн, хүнсний ногоог зориулалтын агуулахад хадгалаагүй, хоол хүнсээр дамжих өвчин болон гэдэсний халдварт өвчин гарсан үед ажиллах журамгүй, дотоод хяналт хангалтгүй, тоног төхөөрөмжүүдэд аюулгүй ажиллагааны шаардлага		
--	--	--	--	--	--	--	--

					хангасан гэрчилгээг хяналтын байгууллагаар гаргуулаагүй, зэрэг зөрчлүүд илэрсэн. Цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.		
7.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. ХАБЭА-н Үндэсний хорооны ажлын хэсэгт орж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын баяжуулах үйлдвэр, авто тээврийн цех, ил уурхай, засвар механикын заводын хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажлын байруудад хяналт шалгалт хийх	-	-	-	ХАБЭА-н Үндэсний хорооны ажлын хэсэгт ажиллаж, 2024 оны 01 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын уулын баяжуулах үйлдвэр, ил уурхай, засвар механикын каюод, тэсрэх бодисын үйлдвэрийн хөдөлмөрийн хэв бус нөхцөлтэй ажлын байруудтай танилцаж, тулгамдаж буй асуудал, илэрсэн зөрчил болон цаашид авах арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	2024.01.11 2024.01.14	100%
8.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. "Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуультай холбоотой өргөдөл гомдол, зөрчил дутагдал гарсан тохиолдолд ХХҮЕГ болон аймаг, дүүргийн ХХҮЕГазар, хэлтэст хандана уу?" гэх постер мэдээллийг сурталчлах талаарх анхаарч ажиллах	-	-		"Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуультай холбоотой өргөдөл гомдол, зөрчлийг хүлээн авах утасны жагсаалтыг шинэчлэн гаргаж, постер болон видео шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.	2024.09.10	100%
9.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. Сайдаас өгсөн чиглэлийн дагуу Скүүтер, мопедоос унаж бэртэх тохиолдлын талаар статистик мэдээллийг нэгтгэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Зам тээврийн яам, нийслэлтэй хэрхэн хамтарч ажиллах талаар судлах				Хүүхэд залуус, иргэд скүүтер, унадаг дугуй, мопед, суррон (цахилгаан дугуй) зэрэг дугуйт тээврийн хэрэгслээс унаж бэртэх, хөдөлмөрийн чадвараа алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол олноор гарч байгаа тул 2023 он, 2024 оны	2024.09	100%

					эхний 8 сарын байдлаар дээрх шалтгааны улмаас унаж бэртэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлсэн, зам тээврийн осолд бүртгэгдсэн иргэдийн статистик мэдээллийг ирүүлэх тухай 03/211, 03/212 дугаартай албан бичгийг Гэмтэл согог судлалын үндэсний төв, Тээврийн цагдаагийн албанд хүргүүлэн, ирсэн мэдээллийг нэгтгэн, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийн газарт хүргүүлсэн.		
10.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 10. Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиг үүрэг, нөхцөл байдлын шинжилгээ хийх	-	-	100%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/45 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиг үүрэг, нөхцөл байдлын шинжилгээ хийж, ажлын хэсгийн ахлагчид нэгтгэж өгсөн.	2024.09	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							

1.	Арга хэмжээ 1. Төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах сургалтад хамрагдах	Төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах цахим болон танхимын сургалтад хамрагдах	Байнга тасралтгүй	ОУХБ, ДЭМБ, ГБХНХЯ,-аас зохион байгуулсан сургалтад хамрагдах	1.ДЭМБ-ын санжүүжилтээр зохион байгуулсан хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчидыг чадавхжуулах 3 өдрийн сургалтад хамрагдсан. 2.“Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 115 улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад 2024.11.25-2024.11.26-ний өдрүүдэд хамрагдаж, мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. 3.“Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөл”-ийн хүрээнд ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын орчин үеийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх сургалтын шинэ модуль хөтөлбөрөөр 30 сургагч багшийг бэлтгэх 16 цагийн сургалтад хамрагдсан.	2024.03.01 2024.12.30	100%
----	--	---	-------------------	---	--	--------------------------	------

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)



(Ч.БҮЖИНЛХАМ)

(Нэр, гарын үсэг)

2024. 12. 09

(Огноо)